



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2005 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2004-2005 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2004 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Бадарчин овогтой Эрдэнэбатыг Австрали улсын Жеймс Күүкийн Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Бямбацоо овогтой Дөлгөөнийг ХБНГУ-ын Лейпциг хотын Удирдлагын сургуулийн магистрантурт менежментийн чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2005-2006 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын газрын Мэргэжлийн боловсролын хэлтэс /Д.Баяр/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2004 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 297 дугаар тушаалын Бадарчин овогтой Эрдэнэбаттай холбогдолтой хэсгийг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2004 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 237 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

297 тушаалд кодификаци хийгдэв.

2004-237 тушаалд кодификаци хийгдэв.



П.ЦАГААН

3745970